



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Тэмдгийн загвар баталж, хэрэглэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын 8.4, 10.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын визийн хуудас дээр дарах “хүчингүй” буюу “void” тэмдгийн загварыг нэгдүгээр, төв болон хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтэст хэрэглэх тэмдгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018 оны А/229 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Д.Давааням)-т даалгасугай.

ДАРГА




Н.УУГАНБАЯР

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
А/38 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ”-Д
ЗААСАН “ХҮЧИНГҮЙ” БУЮУ “VOID”
ТЭМДГИЙН ЗАГВАР

Хүчингүй буюу “VOID” тэмдгийн хэмжээ



1. Тэмдгийн хүрээгээр MNG буюу MONGOLIA гэх бичвэрийн товчлолтой байна.
2. MNG1601 гэдэг нь тэмдгийн дэс дугаарыг тодорхойлно.
3. Тэмдгийн дотор талд байх year ... month ... day ... гэх бичвэр бүхий хэсэгт Монгол Улсын визийг хүчингүй болгосон он сар өдрийг бичнэ.

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн
МЗХ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Төв болон хилийн боомт, орон нутаг дахь
газар, хэлтэст хэрэглэх "VOID" тэмдгийн жагсаалт

Д/д	Зохион байгуулалтын нэгжийн нэр	Тэмдгийн дугаар	Тоо ширхэг
1	Виз, зөвшөөрлийн газар	MNG02-01	2
		MNG02-02	
2	Агаарын замын боомт хариуцсан газар	MNG12-01	2
		MNG12-01	
3	Дорноговь аймаг дахь газар	MNG13-01	3
		MNG13-02	
		MNG13-03	
4	Хойд бүс дэх газар	MNG16-01	5
		MNG16-02	
		MNG16-03	
		MNG16-04	
		MNG16-05	
5	Зүүн бүс дэх газар	MNG17-01	8
		MNG17-02	
		MNG17-03	
		MNG17-04	
		MNG17-05	
		MNG17-06	
		MNG17-07	
		MNG17-08	
6	Өмнөд бүс дэх газар	MNG14-01	2
		MNG14-02	
7	Баруун бүс дэх газар	MNG15-01	6
		MNG15-02	
		MNG15-03	
		MNG15-06	
		MNG15-07	
		MNG15-08	
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	MNG15-04	2
		MNG15-05	
Нийт			30